

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын Зөвлөлийн 1945 оны 4 дүгээр сарын 7-ны өдрийн 23 дугаар хурлын тогтоол.

Утга нь: Нийслэл Улаанбаатар хотын захиргаанд хөдөлмөрийн хэрэг эрхлэх хэлтсийг байгуулах тухай.

БНМА Улсын Сайд нарын Зөвлөлөөс ТОГТООХ нь:

Нэг. Улаанбаатар хотын дотор үйлдвэр, барилга, сангийн аж ахуйнуудад ажиллуулахаар хөдөлмөрийн чадвар бүхий хүмүүсийг бүртгэх ба татах ажлыг удирдах хийгээд энэ ажлыг эрхлэн, зөв зохион явуулах ажил хэргийн үлэмж-хэн байдлыг харгалзан, Ардын Сайд нарын Зөвлөлийн 1944 оны II 6 дугаар хурлын тогтоолын 4-р зүйлийг өөрчлөн, Улаанбаатар хотын захиргаанд хөдөл-мөрийн хэрэг эрхлэх хэлтсийг 3 орон тоотойгоор байгуулахыг Улаанбаатар хотын захиргаанд зөвшөөрсүгэй.

Ерөнхий сайд, улсын шалгарсан баатар, маршал

/ЧОЙБАЛСАН/

Хэрэг эрхлэх газрын дарга

/БАТ-ОЧИР/

Эх материалаас цохисон Мандах.

Нийлсэн: эхийг.....

лавлахыг.....

1962-4-23.